

Mongolian Mining Corporation

Хураангуй Мэдээлэл

ХКБиржийн Код: **0975**



Рейтинг	Худалдан Авах
Ханш (2/15/2011) хкнг.дол	\$10.50
Тооцоолж буй үнэ хкнг.дол	\$13.18
Зах Зээлийн Үнэлгээ (сая хкнг.доллар)	\$38,903
Зах Зээлийн Үнэлгээ (сая ам.доллар)	\$4,992
52 долоо хоногийн өндөр (хкнг.дол)	\$10.92
52 долоо хоногийн бага (хкнг.дол)	\$7.35
Зарласан Хувьцааны Тоо	3,705
Арилжааны дундаж (3 сар; сая ш)	3.9

Хувьцааны Ханшийн Өөрчлөлт



Аналист
Энхбатын Золзаяа
zolzaya@micc.mn
+976 7011-2023

Монголиа Майнинг Корпораци (ММС) нь 2010 оны 10 дугаар сарын 13-нд Хонгконгийн бирж дээр бүртгэгдсэн, үүсгэн байгуулагчийн хувьд Монгол эзэмшигч нараас бүрдсэн уг бирж дээр бүртгэлтэй анхны компани юм. Компанийн хувьцаа нь 0975 кодтой арилжаалагдаж байна.

Бид тус компанийн хувьцааны үнэлгээний эхний судалгаагаа Та бүхэнд танилцуулж байгаа бөгөөд хувьцааны үнийг 13.18 хонгконг доллар буюу одоогийн хаалтын ханшнаас 26 хувиар өндөр үнэлж байна.

Компанийн тухай

ММС нь коксжих нүүрс олборлогч, экспортлогч Монголын хамгийн том хувийн компани юм.

Компанийн 44 хувийг эзэмшдэг MCS Майнинг Групп нь тус компанийн хамгийн том хувь нийлүүлэгч юм. Бусад томоохон хувь нийлүүлэгчдэд Петровис, Шунхлай Групп, EBRD, Керри Групп болон Анкора Капитал ордог. Олон нийт компанийн 22.3 хувийг эзэмшиж байна.

Компанийн хувь нийлүүлэгчдийн бүтцийг Хавсралтаас үзнэ үү.

Нөөц ба Үйл ажиллагаа

Тус компани нь Өмнөговь аймагт орших Ухаа Худагийн нүүрсний ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Ухаа Худаг нүүрсний орд нь 2010 оны 5 сарын 31-ний байдлаар 2,960 га газар бүхий талбайд олон улсын ЖОРК стандартын шаардлагыг хангасан нийт 499.9 сая тонн Хэмжигдсэн ба Тогтоогдсон нүүрсний нөөц баялагтай ба үүнээс 286 сая тонн нь Баттай ба Боломжтой нөөц юм. Нийт нөөц баялгийн 57%-ийг коксжих нүүрс гэж тогтоожээ.

Тогтоогдсон нүүрсний нөөц (2010 оны 5 сарын 31 байдлаар)

	Хэмжигдсэн	Тогтоогдсон	Нийт	Таамагласан
Ил	206	205.3	411.3	11.7
Гүний		88.6	88.6	69.3
Нийт	206	293.9	499.9	81

Эх Үүсвэр: Компани

Ухаа Худагийн уурхай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Таван Толгой нүүрсний ордоос 5 км зайд байрладаг. Компани 2009 оноос уурхайн үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд эхний жил 1.8 сая тн, 2010 онд төлөвлөж байсан 3.8 сая тн түүхий нүүрсээс илүү хэмжээгээр олборлосон байна.

Нүүрс олборлолт болон уурхайн сургалт, тоног төхөөрөмж хангах зэрэг ажлуудыг Leighton Asia компани гэрээгээр гүйцэтгэж байна. Одоогоор Хятадын хил рүү шороон замаар хүнд даацын ачааны тэргээр нүүрсээ тээвэрлэж байна. Нийт 900 гаруй ачааны тэргэ ашиглаж байгаагийн 107 нь ММС-ийн охин компани болох "Трансговь" ХХК-ийн эзэмшилд байдаг бөгөөд бусдыг нь гэрээгээр гүйцэтгэгч компаниуд хариуцаж байна. Нэг ачааны тэргэ нь 80-100 тонн даацтай ба уурхайгаас хил хүртэл 36-48 цагт тээвэрлэлт хийдэг.

Хилийн пост нь долоо хоногийн 6 өдөр, өдрийн 10 цаг нээлттэй байдаг ба Монгол болон Хятадын Засгийн газар 24 цаг болгох асуудлыг хэлэлцэж байгаа.

Ухаа Худаг ил уурхай



Эх үүсвэр: MICC Уурхай дээр авсан зураг, 2011 оны 1 сар

Гол худалдан авагчид

Худалдан авагчдын дийлэнх нь компанитай урт хугацааны гэрээтэй ба Винсвэй худалдааны компани; Чайна Газ, Өвөр Монголын Шинхуа Групп болон гангийн томоохон үйлдвэрүүд болох Баоганг, Шуоганг болон бусад хятадын үйлдвэрүүд байдаг. (Зураг 13)

MMC-ийн Худалдан Авагчид

Төрөл	Компани	Гэрээ хугацаа	Хэмжээ	Гэрээний нөхцөл
Гангийн Үйлдвэр	Баотау Стил	10 жил	0.5-2.0 сая тн; 0.5 сая тн 2010 онд	Зах зээлийн үнэ улирал бүр шинэчилэгдэх
	Шоуганг	5 жил	0.5-2.0 сая тн	Зах зээлийн үнэ улирал бүр шинэчилэгдэх
	Шаганг	10 жил	0.6 сая тн	Зах зээлийн үнэ улирал бүр шинэчилэгдэх
Шинхуа	10 жил	2009 онд 0.8 сая тн, 2010 онд 1.5 сая тн түүхий нүүрс; 2011 оноос 2.0 сая тн угаасан нүүрс		Зах зээлийн үнэ улирал бүр шинэчилэгдэх
	Чайна Газ	1 жил	0.2 сая тн	Зах зээлийн үнэ улирал бүр шинэчилэгдэх
Нүүрс Борлуулагч	Винсвэй Коке	2 жил	0.5-0.8 сая тн 2009.4-2010.4; 1.5-2.0 сая тн 2010.4- 2011	Зах зээлийн үнэ улирал бүр шинэчилэгдэх

Эх үүсвэр: Компанийн мэдээлэл

Цаашдын төлөвлөлт

MMC 2011 онд нийт 7 сая тонн нүүрс олборлох ба 2013 он гэхэд уурхайн хүч чадлыг 14.7 сая тонн хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Нүүрсний хувьд өндөр чанарын коксжих нүүрс бөгөөд 2011 оноос угаасан нүүрсээ экспортлож эхлэхээр төлөвлөж байна.

MMC нь одоо уурхайн дэд бүтцийг хөгжүүлэх үүднээс Ухаа Худгаас Хятадын хил хүртэлх зам тавих, цахилгаан станц байгуулах зэрэг ажлуудыг эхлүүлээд байна. Мөн төмөр зам тавих лиценз авч, Монгол улсын Засгийн газраас ажил эхлэх зөвшөөрлийг хүлээж байна.

Цахилгаан станцын барилга байгууламж



Эх үүсвэр: МИСС Уурхай дээр авсан зураг, 2011 оны 1 сар

Тус компанийн нүүрс угааж боловсруулан нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн барилгын ажил одоо ил явагдаж байгаа бөгөөд энэ чиглэлээр Монголд анхны үйлдвэр болох юм. Үйлдвэрийн барилгын ажлыг Sedgman компанитай хамтран гүйцэтгэж 2011 оны 3 сарын сүүлээр ашиглалтанд оруулахаар зорин ажиллаж байна.

Нүүрс угаах үйлдвэрийн барилга байгууламж



Эх үүсвэр: МИСС Уурхай дээр авсан зураг, 2011 оны 1 сар

Эрсдэл

Компанийн цаашдын үйл ажиллагаа болон хувьцааны үнэ цэнэд сөргөөр нөлөөлөх учирч болзошгүй гол эрсдлүүд нь уурхайн болон дэд бүтцийн өргөтгөлийн зардал нэмэгдэх, уг төсөл удаашрах буюу төлөвлөсөн хугацаанаас хойшлогдох, Хятадын гангийн үйлдвэрлэл буурах, түүхий эдийн бааз суурийн хувьд нэг ордоос хэт хамаарах, хуулийн өөрчлөлт буюу улс төрийн тогтворгүй байдал ба валютын ханшийн хэлбэлзэл зэрэг байх болно.

Төсөл удааширах

Компани уурхайн дэд бүтцийг сайжруулах замаар тээвэрлэх хэмжээгээ нэмэгдүүлж зардлаа багасгахаар төлөвлөж байгаа. Одоогоор нүүрсээ шороон замаар тээвэрлэж байгаа ба 2011 оны хоёрдахь хагаст засмал замыг ашиглалтанд оруулна. Эдгээр төслөөс гадна цахилгаан станц болон 2011 оны 3 сарын сүүлээр ашиглалтанд орох угаах үйлдвэрийн барилгын ажлууд удааширсан тохиолдолд компани нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж зардлаа хэмнэх боломжийг хойшлуулах юм. Үүнээс гадна төлөвлөгдөөгүй зардал бий болох, зардал хэтрэх нь борлуулалтын орлогод сөргөөр нөлөөлөх болно.

Уурхайн кемпийн барилга байгууламж



Эх үүсвэр: MICC Уурхай дээр авсан зураг, 2011 оны 1 сар

2010 оны 12 сарын 14-нд усан хангамжийн байгууламж баригдаж дууссан ба бусад зам, цахилгаан станц, угаах үйлдвэрийн барилгын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна.

Ус хадгалах байгууламжууд



Эх үүсвэр: МИСС Уурхай дээр авсан зураг, 2011 оны 1 сар

Хятадын гангийн үйлдвэрлэл

Хятад улс нь дэлхийн хамгийн том ган үйлдвэрлэгч бөгөөд коксжих нүүрсний үнийг тодорхойлж байдаг. Хятадын эдийн засаг удааширснаар гангийн үйлдвэрлэл буурах бөгөөд энэ нь коксжих нүүрсний эрэлтийг багасгахад нөлөөлнө. Ингэснээр нүүрсний үнэ унах эрсдэлтэй ба компанийн санхүүд муугаар нөлөөлөх юм.

Нэг орд буюу нөөцийн хамаарал

MMC одоогоор Ухаа Худгаас өөр нүүрсний орд газар эзэмшээгүй тул уг ордын лиценз, түүний ашиглалттай холбоотой аливаа асуудал компанийн үйл ажиллагаанд нөлөөлнө.

Төмөр зам байгуулах ажил

Уурхай өргөтгөлийг дэмжин, тээврийн зардлыг багасган ашигт ажиллагааг сайжруулах зорилгоор 2011-2012 онуудад төмөр замын барилгын ажлыг дуусгахаар төлөвлөж байна. Уурхайгаас Хятад улсын хил хүртэл төмөр зам тавихтай холбоотой гол лицензүүдийг авсан ч Монголын ЗГ-аас энэ асуудал эцэслэн шийдэгдээгүй байна. Уг төмөр зам нь Ухаа Худгаас Гашуун Сухайт хүртэл 236 км үргэлжлэх бөгөөд жилд 15 сая тонн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай байх юм. Төмөр замтай холбоотой зардал хэтрэх, хугацаанаасаа хоцрох зэрэг асуудал нь компанийн санхүүгийн зорилтот үзүүлэлтүүд биелэхэд сөргөөр нөлөөлнө.

Улс төр, хууль эрх зүйн орчин

Монголын уул уурхай, ашигт малтмалтай холбоотой хуулиуд сүүлийн хэдэн жил хэд хэдэн удаа өөрчлөгдсөн билээ. Ирээдүйд уг хуульд өөрчлөлт орж болзошгүй юм.

Ухаа Худагийн ордын хувьд МУ-ын ЗГ-ын Ашигт Малтмалын Лиценз Шилжүүлэх Гэрээгээр уг ордын лицензийг цуцлах эсвэл төрийн хувь эзэмшил оруулах байдлаар нэмж өөрчлөлт оруулахгүй гэж заасан байдаг.


Тус компани уул уурхайн 6 лицензтэй байсан нь бүгд стратегийн ач холбогдол бүхий ордын тоонд орсон ба 5 лицензийг нь ЗГ-т шилжүүлэх гэрээнд гарын үсэг зурж харин Ухаа Худагийн лицензийг хэвээр үлдээсэн.

Валютийн ханшийн эрсдэл

Компани Хятад руу нүүрсээ экспортлодог нь валютын ханшийн эрсдлийг бий болгож байгаа. 2009 онд компанийн борлуулалтын өртгийн 79 хувь, үйл ажиллагааны зардлын 13 хувь, капитал зардлын 88 хувь нь долларын гүйлгээ байсан ба үлдсэн хувь төгрөгийн гүйлгээ байсан. 12 сарын 31-ний байдлаар нийт борлуулалтын 77 хувь нь доллараар хийгдэж үлдсэн хувь юанаар хийгдсэн байна.

Одоогийн байдлаар гадаад валютийн эрсдлийг удирдах ямар нэгэн дериватив хэрэгслүүдийг компани ашиглаагүй байгаа ч ирээдүйд хэджинг хийх замаар уг эрсдлээс сэргийлж болох юм.

Америк долларын Төгрөгтэй харьцах ханш



Эх үүсвэр: Монгол Банк

Өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс

Дараах гол давуу тал буюу боломжууд нь компанийн цаашдын өсөлтөд нөлөөлөх болно, үүнд:

- Дэлхийн хэмжээний өндөр чанартай коксжих нүүрсний орд
- Хятадын хилд харьцангуй ойр (240 км)
- Тээвэрлэлттэй холбоотой бүтээн байгуулалт нь цаашид уурхайн үйл ажиллагааны зардлыг эрс бууруулна
- Угаах үйлдвэр нь борлуулах дундаж үнэ ба ашгийн маржинийг нэмэгдүүлнэ

Коксжих чанар

Ухаа Худагийн ордын нүүрсний коксжих чанарын үзүүлэлт (CSN) нь 8.5 гарсан бөгөөд энэ үзүүлэлт 5-аас дээш байх тохиолдолд сайн чанарын коксжих нүүрс гэж үздэг. Иймд хамгийн ойр орших Хятадын зах зээлд амжилттай нийлүүлж борлуулах бүрэн боломжтой.

Зах зээлд ойр

Уурхай үйлдвэр нь Монгол–Хятадын хилээс 240 км, Хятадын Баотау хот хүртэл 360 км зайтай байрладаг. Баотау нь Өвөрмонголын аж үйлдвэр хөгжсөн хот бөгөөд Монгол улсаас Хятадын гангийн үйлдвэрлэлийн муж хүртэл төмөр замаар холбох гол газар юм. Иймд MMC нь Австрали болон бусад далайн боомтоор Хятад руу экспортлодог компаниудтай харьцуулахад байршлын хувьд давуу талтай.

Тээврийн зардал багасна

Компани асфальтан замыг 2011 оны хоёр дугаар хагаст ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Ийнхүү засмал зам тавигдсанаар тээвэрлэлийн хэмжээ нэмэгдэж жилд 18 сая тонн тээвэрлэх хүчин чадалтай болно. Мөн түүнчлэн уурхайгаас Гашуун Сухайт хүртэл төмөр зам тавих гол зөвшөөрлүүдийг авсан.

Угаах үйлдвэр ба бүтээгдэхүүний үнэ

Одоогоор угааж боловсруулаагүй түүхий нүүрсийг зах зээлийн үнээс даруй 35-40 хувиар доогуур борлуулж байгаа туд 2011 онд нүүрс угаах үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар бүтээгдэхүүний үнэ ба ашгийн түвшин нэмэгдэнэ.

Өрсөлдөхүйц бага зардал

Ухаа Худаг нь олон улсын бусад нүүрсний уурхайтай харьцуулахад үйл ажиллагааны зардал харьцангуй багатайд тооцогддог. Wood Mackenzie-ийн судалгаанаас үзэхэд MMC нь тухайн бүсдээ хамгийн бага зардалтай коксжих нүүрс үйлдвэрлэгчдийн нэгд тооцогдож байгаа ба MMC-ийн өрсөлдөгчид үүнээс 2 дахин өндөр зардалтай байгаа юм.

Нөөцөө өсгөх боломж

MMC нь шинээр нүүрсний орд худалдан авах замаар нөөц буюу түүхий эдийн бааз сууриа нэмэгдүүлэх боломжтой.

ҮНЭЛГЭЭ

MMC компанийн хувьцааны үнэлгээг гаргахад дунд хугацаанд өргөжих өсөлттэй бизнесийн загвар бүхий DCF үнэлгээний аргачлалыг ашиглах нь зохимжтой гэж үзсэн. Ийнхүү уурхайн насыг нийт 21 жилээр бодож DCF үнэлгээний 10 хувийн дискаунтын түвшинд тооцсон хувьцааны үнэ ханш 13.18 хонгконг доллар болж байна.

DCF Үнэлгээ

Ам.доллар	FY2011	FY2012	FY2013	FY2014	FY2015	FY2016	FY2017
Хүүгийн өмнөх татварын дараах ашиг	298	490	785	851	912	882	900
Элэгдэл	37	51	54	55	58	56	57
Капитал зардал	(561)	(441)	(67)	(27)	(25)	(21)	(30)
Цэвэр Мөнгөн Урсгал	(227)	101	771	880	945	916	927

Хорогдуулах Хувь 10.0%

	Одоогийн Үнэлгээ	Дилүшн тооцсоны дараа
Компанийн Үнэлгээ	6,329	6,329
Өр Төлбөрийн дүн	(56)	(56)
Бэлэн Мөнгө	15	15
Цөөнхийн Хувь Эзэмшил	-	-
Хувьцааны Үнэлгээ	6,288	6,288
Хувьцааны тоо ширхэг	3,705	3,705
Цэвэр Өнөөгийн Үнэ Цэнэ, ам.доллар	1.70	1.70
Цэвэр Өнөөгийн Үнэ Цэнэ, хкнг.доллар	13.18	13.18

Хувьцааны Одоогийн Ханш 10.5
Өсөх Боломж 26%

Эх үүсвэр: MICC Судалгаа, 2011 оны 1 сар

Үйлдвэрлэлийн хэмжээ

Үйлдвэрлэлийн түвшин 2010-2013 онд 3.9 сая тонноос 15 сая тонн хүртэл өснө гэж төлөвлөсөн ба угаагдах нүүрсний гарц 70 хувь байна.

Нүүрсний Үнийн Таамаглал

Нүүрсний үнийг өөрсдийн тооцоолол болон одоогийн зах зээлийн үнэ ханшийн мэдээлэл ба цаашдын хандлага дээр үндэслэн таамагласан. 2011 оны 3 сарын сүүлээр угаах үйлдвэр ашиглалтанд орж байгаатай холбоотой нийт үйлдвэрлэх нүүрсний тодорхой хэсгийг (угаагдаагүй нүүрс) 35 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулна гэж тооцов. Компани зах зээлд шинээр нэвтэрч байгаатай холбоотойгоор нүүрсний үнэ 2010 оноос 2012 онуудад 10 хувийн хөнгөлөлттэй үнээр зарагдах ба эрчим хүчний нүүрсээ 2013 онд үйлдвэрлэж эхлэнэ гэж таамагласан.

Австралид бий болсон үерийн гамшиг үнийг хөөрөгдөхөд нөлөөлсөн

2011 оны 1-р улиралд 1 тонн коксжих нүүрсний (далайн боомтын) гэрээний үнэ 225 ам.доллар байсан. Бид энэ оны 2-р улиралд нүүрсний үнэ 300 ам.доллар хүрнэ гэж үзэж байна. Нийлүүлэлт дутмаг энэ үед MMC нь угаасан нүүрсээ зах зээлд гаргаснаар их хэмжээний ашиг олох нь тодорхой. Үерийн гамшиг нь 5 тэрбум ам.долларын хохирол үзүүлж дэлхийн хэмжээнд коксжих нүүрсний экспортыг даруй 5 хувиар бууруулсан гэж Квинсландийн ЗГ-аас мэдээлсэн. Квинсланд нь дэлхийн ган үйлдвэрлэлд ашигладаг нүүрсний экспортын 50 гаруй хувийг хангадаг бөгөөд 2010-2011 онд ойролцоогоор коксжих нүүрсний экспортын хэмжээ 15 тэрбум тонноор хойшлогдох эсвэл багасахад хүрээд байна.

2010 оны 12 сард Квинсландийн нүүрсний далайн тээвэрлэлт өмнөх жилээсээ 14 хувиар буурсан ба нийт Австралийн нүүрсний экспорт 2009 оноос 11 хувиар багассан үзүүлэлттэй байна.

Австралийн нүүрсний нийлүүлэлт буурснаас гадна 2 сарын сүүлээр угаах үйлдвэр нь ашиглалтанд орч байгаатай холбоотой MMC худалдах үнээ 2010 онтой харьцуулахад 2 дахин өсгөнө гэж таамаглаж байна.

MICC Нүүрсний Үнийн Таамаглал

	FY2011	FY2012	FY2013	FY2014	FY2015	FY2016	FY2017
Коксжих Нүүрсний Үнэ (ам.доллар/тн)	150	150	167	171	177	174	179

Эх үүсвэр: MICC Судалгаа, 2011 оны 1 сар

Санхүүгийн Мэдээлэл

Орлогын тайлан

MMC нь 2009 оны 4 сараас үйл ажиллагаагаа эхэлсэн ба эхний жилдээ 10 сая долларын ашигтай ажиллажээ. 2010 оноос 2013 онд борлуулалтын орлого 6 дахин өсөх буюу жилд дунджаар 78 гаруй хувиар өснө гэж таамаглаж байна.

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөөр түүхий нүүрсний хэмжээг 2013 он гэхэд 14.7 сая тонн хүртэл өсгөх юм.

Төлөвлөгөөт Орлогын Тайлан

сая ам.доллар	FY2009A	FY2010	FY2011	FY2012	FY2013
Нийт Орлого	67.0	273.0	708.0	1,121.4	1,542.6
<i>Орлогын Өсөлт</i>		308%	159%	58%	38%
Борлуулалтын Өртөг	36.8	151.3	224.8	369.3	372.5
Нийт Ашиг	30.2	121.7	483.2	752.1	1,170.1
Үйл Ажиллагааны Зардал	10.4	31.3	70.4	77.4	100.6
Удирдлагын Зардал	10.4	31.3	70.4	77.4	100.6
Хайгуулын Зардал					
EBITDA(Хүү, Татвар, Элэгдэл Өмнөх Ашиг)	19.7	90.4	412.8	674.7	1,069.5
<i>EBITDA Маржин (%)</i>	29%	33%	58%	60%	69%
Элэгдэл	1.9	3.8	15.3	21.2	23.1
Үйл Ажиллагааны Ашиг, Алдагдал	17.9	86.6	397.5	653.5	1,046.4
Хүүгийн Орлого	0.3	-	-	-	-
Хүүгийн Зардал	3.9	6.8	7.6	3.9	1.6
Үйл Ажиллагааны Бус Орлого, Зардал	0.0	-	-	-	-
Татварын Өмнөх Ашиг	14.4	79.8	389.9	649.6	1,044.7
ТӨА маржин (%)		29%	55%	58%	68%
Татвар	4.1	19.5	97.1	162.0	260.8
Цэвэр Ашиг	10.3	60.2	292.8	487.6	783.9
<i>Цэвэр Ашгийн Өсөлт (%)</i>		486%	386%	66%	61%
<i>Ашгийн Маржин (%)</i>	15%	22%	41%	43%	51%
Эздийн Өмчийн Өгөөж	23%	7%	24%	29%	32%
Хөрөнгийн Өгөөж	9%	5%	21%	26%	29%

Source: MICC Research, January 2011

Борлуулалтын өсөлт

MMC нь 2010 онд өөрийн борлуулалтын төлөвлөгөөгөө биелүүлэн 3.9 сая тонн түүхий нүүрс үйлдвэрлэсэн бол 2013 онд хүчин чадлаа 14.7 сая тонн нүүрс үйлдвэрлэх хэмжээнд хүргэхээр зорьж байна. Ингэснээр 2010 оны 266 сая долларын борлуулалттай харьцуулахад 2013 онд борлуулалт 1543 сая доллар болж өснө.

Үйлдвэрлэлийн өртөг зардал

MMC нь бусад гадаадын өрсөлдөгч нүүрсний компаниудтай харьцуулахад бага зардалтай ажилладаг. Wood Mackenzie-ийн судалгаанаас үзэхэд MMC нь хамгийн бага зардлаар коксжих нүүрс үйлдвэрлэгчдийн нэгд тооцогдож байгаа ба тухайн зах зээлд тоглож буй MMC-ийн өрсөлдөгчид бараг 2 дахин өндөр зардлаар үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Тус уурхайн геологийн бүтэц, орчин нь өртөг зардлыг хямдруулахад нөлөөлсөн.

Татвар

Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 25 хувь ба бусад татварууд Монгол улсын хуулийн дагуу төлөгдөнө.

Бусад

Бид компанийн санхүүгийн загварт дараах таамаглалуудыг тусгаж өгсөн.

Төлөвлөж буй үзүүлэлтүүд

	FY2010	FY2011	FY2012	FY2013	FY2014
Валютын Ханш					
Хонгконг долларын ам.доллартай харьцах ханш	7.765	7.765	7.765	7.765	7.765
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	1,357.04	1,350.00	1,350.00	1,350.00	1,350.00
Юанийн ам.доллартай харьцах ханш	6.776	6.776	6.776	6.776	6.776
Үйлдвэрлэлийн Хэмжээ					
Түүхий Нүүрс	3.90	7.00	10.70	14.70	15.00
Боловсруулсан Нүүрс	-	4.90	7.49	10.29	10.50
Боловруулах хувь (%)		-	70%	70%	70%
Нүүрсний Үнэ					
Сайн Чанарын Коксжих Нүүрсний Үнэ	\$98	\$150	\$150	\$167	\$171

Эх үүсвэр: MICC Судалгаа, 2011 оны 1 сар

Капитал зардал

MMC нь 2013 оны сүүл гэхэд 14.7 сая тонн түүхий нүүрс үйлдвэрлэх түвшинд хүрэх зорилгоор нийтдээ 1.3 тэрбум ам.долларыг УХГ-ийн уурхайд хөрөнгө оруулахаар төлөвлөөд байна.

Капитал Зардлууд

Капитал зардал	Сая ам.доллар
Нүүрс Угаах Үйлдвэр	341.0
Цахилгаан Станц	41.0
Усан Хангамж	49.0
Зам	140.0
Кемп, Онгоцны Буудал, Засвар төв	6.0
Ачааны тэрэг, тоног төхөөрөмж	13.0
Төмөр зам	691.0
Бусад	67.0
Нийт	1348.0

Эх үүсвэр: MICC Судалгаа, 2011 оны 1 сар

Тайлан тэнцэл

Төлөвлөгөөт тайлан тэнцэл

сая ам.доллар	FY2009A	FY2010	FY2011	FY2012	FY2013
Эргэлтийн Хөрөнгө	30	814	551	677	1,426
Бэлэн Мөнгө	2	703	295	269	891
Дансны Авлага	20	82	212	335	461
Бэлэн Бүтээгдэхүүн	8	30	45	73	74
Эргэлтийн Бус Хөрөнгө	83	311	836	1,225	1,238
Үл Хөдлөх Хөрөнгө, Тоног Төхөөрөмж(цэвэр)	74	302	827	1,216	1,229
Бусад Эргэлтийн Бус Хөрөнгө	9	9	9	9	9
Нийт Хөрөнгө	113	1,125	1,387	1,902	2,664
Богино Хугацаат Өр Төлбөр	42	100	104	171	172
Дансны Өглөг	17	67	99	163	165
Банкны Богино Хугацаат Зээл	24	30	-	-	-
Татварын Өглөг	1	3	5	8	8
Урт Хугацаат Өглөг	27	115	80	41	17
Урт Хугацаат Зээл	10	28	16	-	-
Урт Хугацаат Өглөг	17	87	64	41	17
Нийт Өр Төлбөр	69	215	184	212	190
Эзэмшигчдийн Өмч	44	910	1,203	1,690	2,474
Хувьцаат Капитал	-	-	-	-	-
Дахин Үнэлгээ Нөөц	44	850	850	850	850
Цөөнхийн Хувь Оролцоо	-	-	-	-	-
Хуримтлагдсан Ашиг	-	60	353	841	1,625
Нийт Өр Төлбөр, Эзэмшигчдийн Өмч	113	1,125	1,387	1,902	2,664

Эх үүсвэр: MICC Судалгаа, 2011 оны 1 сар

Зах Зээлийн тухай


Ерөнхий

Уул Уурхайн Үндэсний Ассоциациас гаргасан мэдээллээс үзэхэд МУ-ын нийт экспортын орлогын 75 гаруй хувь нь уул уурхайн салбараас бүрдэж байна.

Монголын Нүүрсний Зах Зээл

Монгол Улс нийтдээ 175 тэрбум тонн нүүрсний нөөцтэй ба үүний 10 тэрбумт тонн нь дахин сэргээгдэх нөөц болохыг Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар дурджээ. Эдгээр нөөцийн ихэнх нь батлагдсан ч дэд бүтцийн асуудлаас шалтгаалж ашиглах боломжгүйд хүрээд байгаа ба гол ордууд нь Багануур, Шивээ Овоо, Таван Толгой болон Нарийн Сухайт нүүрсний ордууд юм.

Нүүрсний нөөцийн тархалт, төрлөөр



Эх үүсвэр: АМТХЭГ

Сүүлийн хэдэн жилд нүүрс олборлолтын хэмжээ хурдацтай өсч байгаа ба 2006 онд 8.1 сая тонн байсан бол 2009 онд 14.4 сая тонн болж өссөн ба үүний 49 хувь буюу 7.1 сая тонныг экспортлосон байна. Дотоодын нүүрсний хэрэглээ 2009 онд 6.6 сая тонн болж өссөн нь 2008 онтой харьцуулахад 13 хувиар өсчээ.

Нүүрсний Салбарын Статистик

Категори	2006	2007	2008	2009
Нүүрс Үйлдвэрлэл, сая тонн	8.1	9.2	10.1	14.4
Өсөлт		14%	9%	43%
Дотоодын Хэрэглээ, сая тонн	5.7	5.9	5.8	6.6
Өсөлт		4%	-1%	13%
Экспорт, сая тонн	2.5	3.3	4.2	7.1
Өсөлт		33%	28%	71%

Эх үүсвэр: 2009 оны Статистик

Нүүрсний гол тоглогчид

Эрдэнэс Таван Толгой

Эрдэнэс МГЛ компанийн охин компани Эрдэнэс Таван Толгой ХХК нь 2011 оны сүүлээр IPO хийхээр төлөвлөж байна. Эрдэнэс МГЛ нь стратегийн болон болон улсын хөрөнгө оруулалттай орд газруудад төрөөс төлөөлөх зорилгоор байгуулагдсан.

Эрдэнэс Таван Толгой нь дэлхийн хамгийн том эрчим хүчний болон коксжих нүүрсний ордын нэг болох Таван Толгой нүүрсний ордын лицензийг эзэмшиж байгаа ба одоогоор 6.0-6.5 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэж үзэж байна.

Засгийн газар Эрдэнэс ТТ-н 30 хувийг олон нийтэд санал болгон IPO хийхээр төлөвлөж байгаа ба төрөөс МУ-ын иргэдэд уг ордын 10 хувийг эзэмших эрхийг олгож байгаагаас гадна компаниуд мөн 10 хувийг нь нэрлэсэн үнээр худалдан авах боломжтой юм.

Таван Толгой ХК

Таван Толгой нь 1967 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн улсын өмчит компани юм. Уг уурхай нь том Таван Толгой ордын жижиг хэсэг бөгөөд жижиг Таван Толгой гэж нэрлэгддэг.

1995 онд их хувьчлалын үеэр компанийг хувьчлан 51 хувийг Өмнөговь аймгийн орон нутгийн засгийн газар эзэмшиж, 49 хувийг хөрөнгө оруулагчид эзэмшсэн.

Уурхай нь Улаанбаатар хотоос Өмнөговь аймаг хүртэл 540 км зайтай бөгөөд жижиг ТТ нь том Таван Толгой ордын 169 га талбай бүхий лицензийг эзэмшдэг бөгөөд 60-аад сая тонн өндөр чанарын коксжих нүүрсний нөөцтэй. 2009 онд уурхай ойролцоогоор 2 сая тонн нүүрс үйлдвэрлэсэн.

Саус Гоби Энержи Ресурс

Саус Гоби Энержи Ресурс нь Монголын Өмнөговь бүст хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж Хятад улсад экспортлодог компани юм.

Овоот Толгой нь тус компанийн хамгийн том уурхай бөгөөд 114 сая тонн нүүрсний нөөцтэй ба Шивээ Хүрэнгийн боомт хүртэл 40 км зайтай.

Уурхай 2008 онд ашиглалтанд орсон ба 2012 он гэхэд бүрэн хүчин чадлаараа 9 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөж байна. Уг ордоос гадна хэд хэдэн нүүрсний лицензтэй.

Монголын Алт(МАК)

МАК нь Өвөр Монголын Шинхуа Корп-той хамтран Монгол-Хятадын хамтарсан Шинхуа-МАК-Нарийн Сухайт ХХК-ийг байгуулсан. Уг хамтарсан компанийн гол зорилго нь Нарийн Сухайт нүүрсний төслийн зах зээлийг бий болгох уурхайн дэд бүтэц барилгы ажлыг хөгжүүлэх явдал юм.

Одоогоор жилд 1.5 сая тонн нүүрс олборлон Хятад улсад экспортлож байгаа ба уг ордоос гадна Элдэв Майн нүүрснийн уурхайг 100 хувь эзэмшдэг.

Монголиа Энержи Корпораци (МЕС)

Монголиа Энержи Корпораци (МЕС) эрчим хүч болон ашигт малтмалын хайгуул олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба эзэмшиж буй лицензүүд дээрээ уул уурхайн мэргэжлийн баг байгуулан хайгуул хийх уурхай байгуулан ажилладаг.

МЕС нь одоогоор Монголын баруун бүсд 330 мянган га газар нүүрс, төмөр болон бусад металлын хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшиж

байна. Тус компани Монголын баруун бүсд ЖОРК стандартаар 150 сая тонн коксжих нүүрсний нөөцтэй бөгөөд Монголын өмнө бүсд газрын тос, байгалийн хийн төсөлтэйгээс гадна Хятадын Шинжаанд нүүрсний хэд хэдэн төсөлтэй.

Дэд Бүтэц

Монгол улс нь судлагдаагүй ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийд томоохон тооцогддог ба үүний нэг шалтгаан нь тухайн бүсд дэд бүтэц муу хөгжсөнтэй холбоотой. Тухайлбал Таван Толгой орд нь төмөр замаас 400 км алслагдсан байдаг. Одоогийн байдлаар Монгол Оросыг холбосон Улаанбаатар хотоор дамжин өнгөрөх ганц том төмөр замын урсгалтай.

Ашигт малтмалын ордуудыг ашиглах уурхай байгуулах зорилгоор МУ-ын ЗГ эдгээр ордыг үндсэн гол зах зээлтэй нь холбох төмөр замын сүлжээгээ Хятад улс руу холбон өргөтгөхөөр зорьж байгаа. Түүнчлэн Сайншандад аж үйлдвэрийн томоохон парк байгуулан хурдны замуудтай холбох ажлуудыг төлөвлөгөөндөө оруулсан.

Одоогийн болон Төлөвлөгдөж буй Төмөр Замын Зураг




Эх үүсвэр: Зам Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Яам

Хятадын Нүүрсний Зах Зээл

Хятад нь дэлхийн хамгийн том нүүрс үйлдвэрлэгч бөгөөд хэрэглэгч улс билээ. Дэлхийн Нүүрсний Холбооноос дэлхийн нийт гангийн үйлдвэрлэлийн 70 хувь нь нүүрсээс хамаарж байдгийг тэмдэглэжээ. 2009 онд Хятадын коксжих нүүрсний хэрэглээ 516 сая тонн байсан ба үүний 54 хувийг гангийн үйлдвэрлэлд ашиглажээ. Сүүлийн 10 жил Хятадын ган үйлдвэрлэл их хэмжээний бүтээн байгуулалт, хурдацтай хөгжиж буй хотжилт зэргээс шалтгаалан хурдацтай өсч байна. Гангийн эрэлтийг даган ялангуяа коксжих

нүүрсний эрэлт хурдацтай өсч байна. Нөгөө талаар 2009 онд коксжих нүүрсний үйлдвэрлэлийн хэмжээ 2009 онд 7%-иар буурсан нь тус улсын коксжих нүүрсний эрэлтийг 2008-аас 2009 онд 350 хувь өсгөхөд нөлөөлжээ.


Хятад улсын Ган Үйлдвэрлэлийн Хэмжээ 2005-2011



Эх үүсвэр: Дэлхийн Гангийн Холбоо


Хятадын үл хөдлөх хөрөнгийн бодлого сүүлийн үед үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн өсөлтийг удаашруулсан ба энэ нь гангийн үйлдвэрлэл саарахад хүргэсэн. Хэдийгээр өмнөх жилүүдтэй харьцуулахад гангийн эрэлт тогтворжиж байгаа ч коксжих нүүрсний нийлүүлэлт эрэлтээ хангаж чадахгүй хэвээр байна. Нийлүүлэлт ийнхүү хангалтгүй хэмжээнд удаан үргэлжилвэл Хятадын ЗГ экспортыг бууруулж импортыг нэмэгдүүлэх бодлого явуулах нь гарцаагүй. Энэ Хятадын ашиг муутай уурхайнуудыг зогсоож байгалиа хамгаалах, нөөцийг зөв ашиглах бодлоготой холбоотой.

Хятадын Нүүрсний Импорт ба Экспортын Хэмжээ



Эх үүсвэр: SX Коал

Хавсралт: Хувь Нийлүүлэгчдийн Бүтэц



Эх үүсвэр: Компанийн мэдээлэл

MICC ТУХАЙ

Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци (MICC) нь 2005 онд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан. Монголын өнөөгийн эдийн засгийн эрчимтэй хөгжил болон санхүүгийн таатай орчин компаниудад хөрөнгө оруулалтын боломж, өсөж хөгжих бодит бололцоо олгож байна. Үүнийг ашиглах боломжийг MICC компани хөрөнгө оруулагчид болон харилцагчиддаа нээн өгч, хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ, хөрөнгийн удирдлага, үнэт цаасны андеррайтер, брокерын үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс гадна бид Монголын макро эдийн засгийн судалгаа, дотоодын үйлдвэрлэлийн шинжилгээ болон Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компаниудын талаарх тоймыг гаргаж байна. Бидний зорилго бол дотоодын болон олон улсын компаниудын стратегийн зорилгод нийцсэн, шинэлэг, үр ашигтай санхүүгийн хэлбэрийг сонгож, шаардлагатай хөрөнгө олж авахад нь дэмжлэг үзүүлэх явдал юм. Тийм ч учраас бид уул уурхай, үйлдвэрлэл, санхүү, худалдаа, агаарын тээвэр, барилгын салбаруудад үйл ажиллагаагаа явуулж буй тэргүүлэх компаниудтай удаан хугацаанд хамтран ажиллаж байна.

Холбоо барих хаяг:

Сентрал Таур, 9 давхар, 912 тоот, СБД-8, Улаанбаатар хот

Утас: 70112024, Факс: 70112025

Email: info@micc.mn

ТОДРУУЛГА

Уг судалгааг MICC компанийн судалгааны шинжээчид бие даан бэлтгэсэн бөгөөд аливаа тухайлсан этгээдэд зориулагдаагүй болно. Энэхүү тайланд тусгагдсан аливаа таамаглал нь зөвхөн компанийн шинжээчдийн тооцоолол болно. Тайланд ашиглагдсан мэдээллийн үнэн зөвийг шинжээчид хариуцахгүй. Мөн энэхүү тайланд тусгагдсан үнэт цаастай холбоотой хөрөнгө оруулалтаас үүсч болзошгүй алдагдлыг Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци (MICC) болон Компанийн (MMC) аль нь ч хариуцахгүй болно. Судалгаа хийж буй компанитай Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци хамтран ажиллахыг үгүйсгэхгүй ба уг компанийн захиалгаар судалгааны тайланг хийгээгүй.